

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС 2021 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД БАТЛАН ГАРГАСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

/ЦАГААНДЭЛГЭР СУМ/

2021.06.20

№	Захирамжийн дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт, үр дүн	Хувь
1	A/02	“Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарлах тухай 2021.01.05	2	Хоёр. Бизнес эрхлэгчдийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг бизнес эрхлэгчдийн санал, эрэлт хүсэлтэд тулгуурлан боловсруулан батлуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, биелэлт үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), төлөвлөсөн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга, газар, хэлтэс, албадын дарга нарт тус тус үүрэг болгосугай.	ХОХБТХ	Бизнесийн хяналт зохицуулалт, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, түүний тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулан батлууллаа. Жилийн ажлын хүрээнд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэрийг дэмжихийн зэрэгцээ, томоохон компаниудын нийгмийн хариуцлагатай ажиллах санаачлагуудыг хөгжүүлэн ажиллах, шинэлэг, үр дүнтэй, шилдэг шийдлээр өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхийг бий болгох, байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжих, бизнес эрхлэгчдийн өсөлт, дэвшлийн хөшүүрэг нь болж, иргэд, харилцагч нэг бүрийн хэрэгцээнд тохирсон үнэ цэнэтэй, үр дүнд чиглэсэн бизнес хөгжлийн шийдлийг үзүүлэх, бизнес эрхлэгчид өөрийн туршлагуудаа хуваалцах боломжуудыг олгох болон үйлдвэрлэл, бизнесийн зорилгоор ажлын байр, тоног төхөөрөмж зээлээр худалдан авах зэрэгт мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээг цогц хэлбэрээр хүргэх зэрэг ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна.	30
2	A/27	Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай 2021.01.18	8	Хоёр. Тус захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	СТСХ МХГ Сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Төсөвт байгууллагын ажилчдын цалингийн зээл сарын сүүлээр төлөгддөг тул цалинг 2 хувааж авахаар сарын эцэст зээлээ төлж чадахгүй байна гэсэн албан хаагчдын саналын дагуу цалинг сард 1 удаа тооцож олгож байна. Цалингаа 2 хувааж авах боломжтой, авахыг хүссэн иргэдэд тухайн үед нь цалингийн урьдчилгаагаар сард 2 удаа олгож байна.	70

3	A/56	Ажлын хэсэг байгуулах тухай 2021.02.15	12	Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумдын өнгө үзэмжийг сайжруулах, ашиглалтгүй байгаа барилга байгууламжийг цаашид ашиглах эсэх талаар шийдвэрлэж тодорхой арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Сумдын Засаг дарга нар	Сумын өнгө үзэмжийг сайжруулах, ашиглалтгүй байгаа барилга байгууламжийг засварлуулах, шаардлага хангахгүй барилгыг буулгуулан хүлээж авах ажлын хэсгийг байгуулан эгнээ хариуцсан гишүүд иргэн, ААН, албан байгууллагуудад мэдэгдэл хүргэн ажиллаж байна. ОНХС-ын хөрөнгөөр засварлах 1 ажлын тендер зарлагдсан.	30
4	A/93	Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай 2021.03.09	16	Хоёр. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн нийтлэг хэрэгжүүлэх зөвлөмж, Хяналт - шинжилгээний үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжилт үр дүнг тооцон зөвлөмжийн хэрэгжилтийг 6, 11 сарын 25-ны дотор Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст тайлагнахыг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.	Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар	2020 оны сумын Засаг даргын Тамгын газар, харъяа төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2021.03.26-ны өдөр сум Засаг даргаар батлуулан хяналтандаа авч холбогдох байгууллага, албан хаагчдад хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарах асуудлуудын талаар чиглэл өгсөн. 2021.06.28-ны өдөр зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож гарган ХШҮДАХ-т хүргүүлсэн.	100

5	A/142	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.04.10	10	9. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, зайлшгүй шаардлагаар голомтын бүс нутгаас нэвтэрч байгаа болон Өмнөговь аймгаас ирж буй иргэдийн PCR шинжилгээний хариуг сайтар нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд авч 7 хоног хяналт тавьж, шинжилгээний дүнг үндэслэн гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ЭМГ Сумдын Засаг дарга нар	Тусгаарлан ажиглах байранд голомттой бүсээс ирсэн 2 иргэнийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулж тусгаарлах байранд 7 хоног ажиглан хянаж үргэжлүүлэн 7 хоногийн гэрийн ажиглалтанд шилжүүлж цагдаагийн хэсэгтэй хамтран хяналт тавьж ажилласан.	100
6	A/143	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.04.11	11	1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахал батлагдсантай холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 14.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 14.00 цаг хүртэл аймаг сумаас орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлаж хяналтын цэгүүдийг нэмэгдүүлж хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ОБГ ЦГ	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шалган нэвтрүүлэх хяналтын цэгт нийт 28 алба хаагчид 24 цагаар ажиллан шалган нэвтрэх цэгээр нэвтэрч байгаа автомашин, иргэдийн хөдөлгөөнд хяналт шалгалтыг хийж, зайлшгүй шаардлагаар голомтын бүсээс ирсэн иргэдийн PCR шинжилгээний хариуг нягтлан шалгаж, шаардлагатай тохиолдолд түргэвчилсэн шинжилгээнд хамруулан хяналтаар нэвтрүүлж ажилласан.	100

			12	2. Дээрх хугацаанд архи, согтууруулах ундааны зүйлс худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг дээрх хугацаанд хориглож, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ЦГ Засаг дарга нарт	Тогтоосон хугацаанд согтууруулах ундаа худалдан борлуулдаг 2 аж ахуйн нэгжийн согтууруулах ундааг лацдаж 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 14.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийг хүртлэх хугацаанд хяналт тавин ажиллахад ямар нэг зөрчилгүй байсан.	100
7	А/144	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.04.14	18	1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 06.00 цаг хүртэл хугацаанд шилжүүлж хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ОБГ ЦГ	Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 06.00 цаг хүртэл хугацаанд шилжүүлсэнтэй холбогдуулан сумын Онцгой комиссын хуралдааны шийдвэрийн дагуу сумын Засаг даргын тоот захирамжаар бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж хяналтын цэг, шуурхай штабын 24 цагийн жижүүрийн хуваарийг тодотгон хяналт тавьж ажилласан.	100
			19	2. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахал батлагдсантай холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 14.00 цагаас эхлэн Эрдэнэдалай сумаас бусад сумдын орох, гарах хөдөлгөөнийг хэвийн үргэлжлүүлж хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ОБГ ЦГ	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шалган нэвтрүүлэх хяналтын цэгт нийт 28 алба хаагчид 24 цагаар ажиллан нэвтэрч байгаа автомашин, иргэдийн хөдөлгөөнд хяналт шалгалтыг хийж, зайлшгүй шаардлагаар голомтын бүсээс ирсэн иргэдийн PCR шинжилгээний хариуг нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж ажилласан.	100

			20	5. Хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 21.00 цагийн хооронд байхаар тогтоож хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт даалгасугай.	МГ ЦГ	Сумын төвд үйл ажиллагаа явуулдаг 4 хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 20.00 цагийн хооронд байхаар тогтоож, тогтоосон хугацаанд хяналт тавин ажиллахад ямар нэг зөрчилгүй.	100
			23	9. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, зайлшгүй шаардлагаар голомтын бүс нутгаас нэвтэрч байгаа болон Өмнөговь аймгаас ирж буй иргэдийн PCR шинжилгээний хариуг сайтар нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд авч 7 хоног хяналт тавьж, шинжилгээний дүнг үндэслэн гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ЭМГ	Коронавирусын голомттой бүс нутгаас нэвтэрсэн 32 иргэний PCR шинжилгээний хариуг нягталж дамжин өнгөрүүлж, 2 иргэнийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж 7 хоног тусгаарлан ажиглах байранд хянаж, 7 хоногийн гэрийн ажиглалтанд шилжүүлэв.	100
8	A/146	Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар	24	4. Сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан, тэмцэх талбай болон сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гэрээний биелэлтэд хяналт тавих, тайлан мэдээг хугацаанд нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж	ХХААГ	Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг 2021.05.05-2021.05.15-ны хооронд зохион байгуулж тайлан мэдээг 3 хувь үйлдэн ХХААГ-т заасан хугацаанд хүргүүлсэн. Нийт 30 сая төгрөгийн үнэ бүхий бактержуулсан будааг 6000 га талбайд 4 багийн Засаг даргаар ахлуулсан 20 хүний бүрэлдэхүүнтэй	100

		тэмцэх ажлыг зохион байгуулах 2021.04.15		ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхжаргал, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.		4 ажлын хэсэг, 5 автомашинтайгаар 4 багийн нутгаар оготно ихээр тархсан, зураглагдсан талбайд цацаж, үлийн цагаан оготной тэмцэх ажлыг чанартай сайн гүйцэтгэж дуусгасан.	
9	A/154	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.04.19	29	1. Сургуулийн дотуур байрыг тусгаарлан ажиглах байраар тохижуулж, иргэд байрлах өрөөнд байх болон бусад шаардлагатай зүйлсийг Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 31 дүгээр тушаалд заасны дагуу бэлтгэж, бэлэн байдлыг хангахыг Сумдын Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.	НБХ МХГ Сумдын Засаг дарга нар	Сургуулийн дотуур байрыг тусгаарлан ажиглах байраар тохижуулж иргэд байрлах 5 өрөөнд байх шаардлагатай зүйлсийг Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 31 дүгээр тушаалд заасны дагуу бэлтгэж, бэлэн байдлыг хангасан. Өрөө тус бүр 3-4 ортой.	70
10	A/156	Дэмжлэг үзүүлэх тухай 2021.04.20	31	2. Сэг зэм устгах ажлын зардалд шаардагдах 13,000,000 (арван гурван сая) төгрөгийг хандив тусламжийн хөрөнгөнөөс гаргаж олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван)-д, тухайн ажлыг технологид хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүй удирдлагаар хангаж, биелэлтэд хяналт тавьж дээрх сумдын удирдлагуудтай хамтарч ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (Ш.Мөнхдүүрэн), аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Мал эмнэлгийн газар ХХААГ сумдын Засаг дарга нар	Сумын Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 15-ны А/146 тоот захирамжаар малын сэг зэм устгах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж адуу 373, үхэр 313, хонь 3349, ямаа 4767, амьтан 1, нийт 8803 сэг зэм устгаж 290 м2 талбайд халдваргүйжүүлэлт хийсэн байна. Сэг зэм устгалын ажилд аймгийн Онцгой комиссоос 2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээс сэг зэм устгалын ажилд оролцож буй албан хаагчдын хоол хүнс, тээвэрлэж буй автомашины түлш, шатахуунд зарцуулсан байна.	100

11	A/159	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.04.24	33	2. Коронавируст (КОВИД-19)-ын өвчлөл батлагдсантай холбогдуулан аймаг, сумдаас орох гарах хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ОБГ ЦГ	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шалган нэвтрүүлэх хяналтын цэгт нийт 28 алба хаагчид 24 цагаар ажиллан нэвтэрч байгаа автомашин, иргэдийн хөдөлгөөнд хяналт шалгалтыг хийж, зайлшгүй шаардлагаар голомтын бүсээс ирсэн иргэдийн PCR шинжилгээний хариуг нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж ажилласан.	100
			34	5. Хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 21.00 цагийн хооронд байхаар тогтоож, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт даалгасугай.	МХГ ЦГ сумдын Засаг дарга нар	Сумын төвд үйл ажиллагаа явуулдаг 4 хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 20.00 цагийн хооронд байхаар тогтоож, тогтоосон хугацаанд хяналт тавин ажиллахад ямар нэг зөрчилгүй байлаа.	100
			36	7. Архи, согтууруулах ундааны зүйлс худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглож хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт даалгасугай.	ЦГ МХГ	Тогтоосон хугацаанд согтууруулах ундаа худалдан борлуулдаг “Сайнгашуун” ХХК, “УГТААЛ ТРЕЙД” ХХК-ны хүнсний дэлгүүрүүдийн согтууруулах ундааг лацдаж, хяналт тавин ажиллахад ямар нэг зөрчилгүй байсан.	100
			40	11. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, зайлшгүй шаардлагаар голомтын бүс нутгаас нэвтэрч байгаа болон Өмнөговь аймгаас ирж буй иргэдийн PCR	ЭМГ	Голомттой бүс нутагаас ирсэн 2 иргэний PCR шинжилгээний хариуг шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан тусгаарлан ажиглах байранд 7 хоног байрлуулж хяналт тавьж , 7 хоногийн гэрийн ажиглалтанд шилжүүлсэн.	100

				шинжилгээний хариуг сайтар нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд авч 7 хоног хяналт тавьж, шинжилгээний дүнг үндэслэн гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.			
12	A/177	Мал бүртгэлжүүлэлтийн аян зохион байгуулах тухай 2021.05.04	44	3. Аяны хүрээнд малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-т, орон нутагт ажиллах хүчнийг зохион байгуулж, технологид хугацаанд багтаан чанартай, үр дүнтэй зохион байгуулж тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХХААГ	Мал бүртгэлжүүлэлтийн аяны хүрээнд 2, 3-р багийн 100 хээлтүүлэгч малыг ээмэгжүүлэн малын бүртгэл мэдээллийн системийн нэгдсэн санд бүргэж байна. Мэдээ судалгааг Хүнс хөдөө аж ахуйн газар мэдээллээ.	30

13	A/180	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.05.07	45	2. Дээрх хугацаанд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг диско баар, цахим тоглоом болон хүүхдийн тоглоомын газар, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, сүм хийдийн болон бусад хурал, цуглаан, үзэсгэлэн худалдаа, караоке, аялал зугаалга, хурим, найр, саун, бассейн, фитнес, спорт заал, амралт, жуулчны газар, бүх төрлийн сургалтын арга хэмжээ зохион байгуулахыг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд хориглож, бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 21.00 цагийн хооронд байхаар тогтоож хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	МХГ ЦГ Сумдын Засаг дарга нар	2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг диско баар, цахим тоглоомын газар байхгүй. Олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, бүх төрлийн сургалтыг зохион байгуулаагүй. Үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагын ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 20.00 цагийн хооронд байхаар тогтоож үүнд хяналтыг тогтмол тавин ажилласан ба тогтоосон хугацаанд ямар нэг зөрчилгүй байсан.	100
			47	4. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, зайлшгүй шаардлагаар голомтын бүс нутгаас нэвтэрч байгаа коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 2 тунд бүрэн	ЦГ МХГ ЭМГ Сумдын засаг дарга нар	Коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 1-р тунд хамрагдсан 16 иргэний PCR шинжилгээнд үндэслэн түргэвчилсэн шинжилгээнд хамруулж 14 хоногийн гэрийн ажиглалтанд авсан.	100

				хамрагдсанаас хойш 14 хоног болсон, сүүлийн 4 сарын хугацаанд коронавирусын халдвараар өвчилж эдгэрсэн иргэдээс бусад иргэдийн PCR шинжилгээний хариуг сайтар нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд авч 7 хоног хяналт тавьж, шинжилгээний дүнг үндэслэн гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.			
			48	8. Аймгийн нутаг дэвсгэрт барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилчдыг нэвтрүүлэх түр журмыг баталж, мөрдүүлэн хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ЦГ МХГ ЭМГ ГХБХБГ Сумдын Засаг дарга нар	Аймгийн нутаг дэвсгэрт барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилчдыг нэвтрүүлэх түр журмын хэрэгжилтийг хангаж тус сумын төвд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Соёлын төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байгаа Хэрмээдэй ХХК-ны 18 ажилтны вакцины бүрэн тунд хамрагдсан эсэх, мөн шинжилгээний хариуг нягтлан шалгаж барилгын хашаанд тусгайлан бэлтгэсэн байранд 14 хоног тусгаарлан ажиглаж хяналт тавьж ажилласан.	100
14	A/191	Төрийн байгууллагуудын ажлын	55	2.Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд сурталчилж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг	ЗДТГ сумдын Засаг дарга, аймгийн төрийн	Аймгийн Засаг даргын 2021.05.19-ний өдрийн A/191 дүгээр захирамжаар батлагдсан “Төрийн байгууллагуудын ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” захирамжийг харъяа төсвийн	100

		цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2021.05.19		даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат)-д, сумдын Засаг дарга, аймгийн төрийн байгууллагуудын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.	байгууллагуу дын дарга, удирдлагууд	байгууллагуудад хүргүүлж 2021.06.01-ний өдрөөс 2021.09.01 хүртэл хугацаанд ажлын цагийг 08.00-17.00 цагийн хооронд мөрдөж ажиллах талаар цахим сүлжээнд байршуулж иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.	
15	A/193	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.05.21	57	1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг диско баар, цахим тоглоом болон хүүхдийн тоглоомын газар, амралт, жуулчны газар, үзэсгэлэн худалдаа, хурим найр, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулахыг 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 02–ны өдөр хүртэлх хугацаанд хориглож, бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 21.00 цагийн хооронд байхаар тогтоож хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай	МХГ ЦГ Сумдын Засаг дарга нар	Сумын нутаг дэвсгэрт олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулахыг 2021 оны 05 дугаар сарын 22- ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 02–ны өдөр хүртэлх хугацаанд хориглож, бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 20.00 цагийн хооронд байхаар тогтоож хяналт тавин ажиллахад ямар нэг зөрчилгүй байсан.	100

			58	2.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын 2 тунд бүрэн хамрагдсанаас хойш 14 хоног болсон, сүүлийн 4 сарын хугацаанд коронавирусын халдвараар өвчилж эдгэрсэн иргэдээс бусад иргэдийн PCR шинжилгээний дүнг үндэслэн, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан гэрийн ажиглалтад 14 хоног шилжүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	МХГ ЦГ Сумдын Засаг нар	Коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 2 тунд хамрагдсан боловч 14 хоног гүйцээгүй 5 иргэний PCR шинжилгээнд үндэслэн түргэвчилсэн шинжилгээнд хамруулж 14 хоногийн гэрийн ажиглалтанд авсан. Бага насны 4 хүүхдийг, гэр бүлийн хамт 14 хоногийн гэрийн ажиглалтанд авсан.	70
16	A/201	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.06.03	63	2.Коронавируст (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг диско баар, цахим тоглоом болон хүүхдийн тоглоомын газар, амралт, жуулчны газар, үзэсгэлэн худалдаа, хурим найр, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулахыг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд хориглож, хяналт	ЦГ Сумдын Засаг дарга нар	Сумын нутаг дэвсгэрт олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулахыг 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд хориглож, бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 18.00 цагийн хооронд байхаар тогтоож хяналт тавин ажиллахад ямар нэг зөрчилгүй байсан.	100

				тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.			
			64	3. Дээрх хугацаанд аймгийн хэмжээнд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 2 тунд бүрэн хамрагдсанаас хойш 14 хоног болсон, сүүлийн 4 сарын хугацаанд коронавирусын халдвараар өвчилж эдгэрсэн иргэдээс бусад иргэдийн PCR шинжилгээний дүнг үндэслэн, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан 7 хоног гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ЦГ ЭМГ Сумдын Засаг дарга нар	Коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 1-р тунд хамрагдсан 3 иргэний PCR шинжилгээнд үндэслэн түргэвчилсэн шинжилгээнд хамруулж 7 хоногийн гэрийн ажиглалтанд авсан. Коронавирусыг халдварлагдсан 7 тохиолдол бүртгэгдэж ойрын хавьтлын 95 хүнийг түргэвчилсэн болон PCR шинжилгээнд хамруулж, 14 хоногийн гэрийн ажиглалтанд авсан.	100
17	A/205	Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай 2021.06.07	69	3. Сонгуулийн санал хураалтын үеэр иргэд, олон нийтийн хэв журмыг сахиулж, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, иргэд сонгогчдын аюулгүй байдлыг хангаж, захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	ЦГ МХГ Сумдын Засаг дарга нар	2021 оны 06 сарын 09-ний өдрийн Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын өдөр иргэд, олон нийтийн хэв журмыг сахиулж, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, иргэд сонгогчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр эргүүл хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, сонгуулийн санал авах байрны хамгаалалтанд тогтмол хяналт тавин ажилласан.	100

18	A/207	Хязгаарлалт тогтоож, тэг зогсолт хийх тухай 2021.06.10	73	3. Хяналтын цэгүүдийн тоог нэмэгдүүлж, холбогдох байгууллагуудын алба хаагчдыг дайчлан хөдөлгөөнийг хязгаарлаж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ЦГ ОБГ	Тэг зогсолт хийсэнтэй холбогдуулан зайлшгүй хүндэтгэх шалтгаанаар сумын төвөөр дайран өнгөрч буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон иргэдийн хөдөлгөөнд хяналт тавин нэмэлтээр сумын шуурхай штабын жижүүрийг хөдөлгөөнт эргүүлээр нэмэгдүүлэн ажилласан.	100
			75	6. Зайлшгүй шаардлагатай өргөн хэрэглээний хүнс, ус, эм, эмнэлгийн хэрэгслийн хүргэлтийн үйлчилгээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), “Дундговь-Ус” ОНӨҮГ (О.Бархүү), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХОХБТХ ХХААГ Дундговь-Ус ОНӨҮГ	Коронавируст / КОВИД-19/ -ын халдварын сэжигтэй тохиолдол илэрч батлагдсантай холбогдуулан хязгаарлалт тогтоож, тэг зогсолтыг хийж, ард иргэдэд зайлшгүй шаардлагатай өргөн хэрэглээний хүнс, ус, эм, эмнэлгийн хэрэгслийн хүргэлтийн үйлчилгээг зохион байгуулан батлагдсан цагийн хуваарийн дагуу ажиллалаа. Үүнд: Эм эмнэлгийн хэрэгсэл, ундны ус, хүргэлтийг 80648580 дугаарт ирүүлсэн дуудлагаар, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг Баянзалаат ХК-ны 89781545 дугаарт, Сайнгашуун ХХКомпанийн 80901976 дугааруудад ирүүлсэн дуудлагын дагуу хүргэлтийг тухайн аж ахуй нэгжүүд хүргэж ажилласан. Хүргэлтийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгжүүд мэргэжлийн байгууллагаас өгсөн халдвар хамгааллын дэглэм, заавар зөвлөмжийг чанд баримтлаж үйлчилгээг оновчтой хүргэж ажиллаж байгаад хяналт тавьж ажиллалаа.	100
			77	10. Халдвар бүртгэгдээгүй сумуудад сумын Засаг даргын захирамжаар коронавирус (COVID-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх болон тандалт судалгааны ажлыг зохион байгуулж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг сумдын	Сумдын Засаг дарга нар	2021.06.10-2021.06.15-ны өдөр хүртэл Коронавирусын халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор суманд 5 хоногийн 0 зогсолтын арга хэмжээ зохион байгуулагдсан. 2021.06.07-ны өдрөөс 2021.06.21-ний өдрийн хооронд тус суманд коронавирусын 7 халдвар бүртгэгдэж тандалт судалгаа хийн ойрын хавьтлын 94 хүнээс Коронавируст халдварын	100

				Засаг дарга нарт үүрэг болгосугай.		түргэвчилсэн шинжилгээ авч сөрөг гарч, PCR-ын 78 шинжилгээ авч ДУА-ийн НЭ-т зөөвөрлөж хариу арга хэмжээг зохион байгуулж 7 иргэнийг эмчлэн эмнэлгээс гаргаж гэрийн ажиглалтанд шилжүүлэн хянаж байна.	
19	А/209	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.06.14	78	3. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүдэд согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэхийг тус хугацаанд хориглож, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ЦГ	Тогтоосон хугацаанд согтууруулах ундаа худалдан борлуулдаг “САЙНГАШУУН” ХХК, “УГТААЛ ТРЕЙД” ХХК-ны хүнсний дэлгүүрүүдийн согтууруулах ундааг лацдаж, хяналт тавин ажиллахад ямар нэг зөрчилгүй ажиллаж байна.	100
			79	4. Хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 09:00 цагаас 18:00 цагийн хооронд ажиллахаар тогтоож халдвар хамгааллын дэглэмийг сахиулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т, цагийн хуваарь хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	МХГ ЦГ сумдын Засаг дарга нар	Сумын төвд үйл ажиллагаа явуулдаг 4 хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 18.00 цагийн хооронд байхаар тогтоож, тогтоосон хугацаанд хяналт тавин ажиллахад ямар нэг зөрчилгүй ажиллаж байна.	100
			82	10. Дээрх хугацаанд аймгийн хэмжээнд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр коронавирус /КОВИД-19/-ын голомтот бүс нутгаас нэвтэрч байгаа сүүлийн 4 сарын хугацаанд коронавирусын халдвараар өвчилж эдгэрсэн иргэдээс бусад иргэдээс төлбөртэй түргэвчилсэн	ЭМГ	2021.06.14-06.25-ны өдөр хүртэл сумын ЭМТ коронавирусын халдварын голомтот бүс нутгаас ирсэн 11 хүнд коронавирусын түргэвчилсэн шинжилгээг төлбөртэй хийх ажлыг зохион байгуулсан байна.	100

				шинжилгээ авч, гэрийн ажиглалтад 7 хоног шилжүүлэх, вакцины бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоног болсон иргэдийг шаардлагтай тохиолдолд тусгаарлах байр, гэрийн ажиглалтад шилжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.			
	100 хувь-28, 70 хувь-3, 30 хувь-3, 0 хувь-, ҮБ-, ХБ-						91.2

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР